



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар

А/1458

Улаанбаатар хот

Газар эзэмшүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 21.5.4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг батлах тухай 06 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2025 оны Эрх шилжүүлэх тухай А/1458 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар дээрээ олон жил амьдарч байгаа холбогдох журамд нийцсэн иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хавсралтад дурдсан нэр бүхий 144 (нэг зуун дөчин дөрөв) иргэнд газар эзэмшүүлэх эрх олгосугай.

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Н.Насанбуян)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ